2026 оны 6-р сарын 16

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



Улсын ерөнхий прокурорын газраас санаачлан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын Хуульчдын холбоотой хамтран зохион байгуулж буй “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд прокурорын гүйцэтгэх үүрэг: Хууль бус хөрөнгийг мөшгөх, буцаан авах ба хүлээлгэх хариуцлагын тогтолцоо” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал (2026.06.16) Улаанбаатар хотноо боллоо.







Тус хурлын гол зорилго нь зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд прокурорын гүйцэтгэх үүрэг, хууль бусаар олсон хөрөнгийг мөшгөх, царцаах, хураах, буцаан авах болон холбогдох хариуцлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалт, практик хэрэгжилт, хамтын ажиллагаанд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх үр нөлөөтэй арга замыг тодорхойлоход оршиж байна.


FELIX GLENK
RESIDENT REPRESENTATIVE OF
THE HANNS SEIDEL
FOUNDATION IN MONGOLIA
KHOSBAYAR.CH


MUNKHBAT.M
LONG DUC NGUYEN
CHINBAT.M



Хуралд Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Феликс Гленк нар оролцож, хурлын ач холбогдол агуулгыг тодотгож үг хэллээ.

Хурлын үндсэн илтгэлийг Чингис хаан одонт, Шинжлэх Ухааны академийн жинхэнэ гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Нарангэрэл “Олон Улсын шинжтэй зохион байгуулалттай гэмт хэрэг ба Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүллээ.







Мөн хууль бусаар хөрөнгийг мөшгих, буцаан авах, тулгарч буй сорил, прокурорын үүрэг оролцооны талаар ХБНГУ-ын Бавари мужийн Мюнхений прокурорын газрын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, хөрөнгө буцаах газрын дарга Хильдегард Боймлер-Хёсл, БНСВУ-ын Ардын дээд прокурорын газрын Эдийн засаг, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих газрын дарга Дао Динк Чаонг, Бүгд

Найрамдах Азербайжан Улсын ерөнхий прокурорын газрын Тусгай хураан авах ажиллагааны зохион байгуулах газрын орлогч дарга Гюнай Айюбова нар илтгэл хэлэлцүүллээ.








IGN AFFAIRS
IA
NAMSAMAND.A
MYAGMARNARAN.D
ENKHBOLD.B
ALTANGEREL.O
MEMBER OF THE PARLIAMENT OF MONGOLIA



Олон улсын эрдэм шинжилгээний хуралд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO), Транспэрэнси Интернэшнл Монгол ТББ-ын төлөөлөл, Монгол Улсад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар Улсын ерөнхий прокурорын газар, Улсын дээд шүүх, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, УИХ-ын тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 16 илтгэл хэлэлцүүлсэн юм.



Тус олон улсын эрдэм шинжилгээний хуралд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын төсөл, хөтөлбөрийн судлаач, эрдэмтэн, шүүгч, прокурор, хууль сахиулагч зэрэг 120 орчим хүн оролцлоо.


1.Финланд: 0.868
2.Норвеги: 0.849
3.Сингапур: 0.838
4.Нидерланд: 0.832
5.Данк: 0.830
МОНГОЛ УЛС 125 УЛС ОРНООС 48-Т
эрэмбэлэгдсэн. Оноо: 0.580
Чадамж (Capacity): 0.580
Нэвц болон дад бүтцийн хангамж сайн.
Үйл явц (Process): 0.410
Нөөцийн үр ашиггүй байдал, шууд
тогтолцооны харааг бүс байдал, авлигын
эрсдэл сул.
Хууль ёсны байдал (Legitimacy): 0.010
Аюулгүй байдлыг хангагч
байгууллагуудад хандах иргэдийн
хандлага, итгэл итгэл, шударга шүүх үйл
ажиллагааны үнэлгээ дунджаас.
Үр дагавар (Outcomes): 0.580
Дотоод аюулгүй байдалд заналхийлэх буй
бодит аюул заналын түвшин дунджаас.
ДЭЛХИЙН ДОТООД АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА
ЦАГДААГИЙН ИНДЕКС 2023 он
(WORLD INTERNAL SECURITY & POLICE INDEX 2023)
No Data
Best Performing
Worst Performing


MINISTRY OF FOREIGN AFFAIRS
MONGOLIA



Видео: https://www.youtube.com/watch?v=0cgdrj5J-lw

Эх сурвалж: https://prosecutor-research-institute.greensoft.mn/post/3495